



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2012 оны 19 сарын 14 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Эрх олгох тухай

“Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” хуулийн 12.2 дахь хэсэг, “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 19.3 дэх хэсгийг удирдлага болгон ТУШААХ нь:

1.Төсвийн ерөнхийлөн захирагчийн хавсралтад заасан харилцах дансдын гүйлгээнд нэгдүгээр гарын үсэг зурах эрхийг Төрийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч Б.Батзаяад, хоёрдугаар гарын үсэг зурах эрхийг Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч, Сайдын багцын ерөнхий нягтлан бодогч З.Цэрэнчимэг нарт олгосугай.

2.Улсын төсвийн болон гадаадын зээл, хандив, буцалтгүй тусламжийн хөрөнгийг батлагдсан төсөв, төлөвлөгөөг үндэслэн зориулалтын дагуу зарцуулж, хуулиар олгогдсон эрх, үүргийг чанд сахин биелүүлж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч Б.Батзаяа, Сайдын багцын ерөнхий нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэгч З.Цэрэнчимэг нарт үүрэг болгосугай.


3.Энэхүү тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Стратегийн бодлого төлөвлөлтийн газар, Төрийн захиргааны удирдлагын газарт тус тус үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын “Эрх олгох тухай” 2012 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 95 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



А.ГАНСҮХ

Зам, тээврийн сайдын 2012 оны 9 сарын 13 өдрийн
13-тоот тушаалын хавсралт



Зам тээврийн яамны Төв төрийн сан дахь дансны жагсаалт

№	Байгууллага	Дансны дугаар	Дансны нэр
1	Зам тээврийн яам	900028300	Хөрөнгө оруулалт
2		900028304	Эрх шилжсэн хөрөнгө хөрөнгө оруулалт
3		900028007	Үйл ажиллагааны урсгал зардал

Худалдаа хөгжлийн банкны дансны жагсаалт

1	ЗТБХБЯам	499040193	Валютын харилцах данс
---	----------	-----------	-----------------------

_____ оОо _____